



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/304

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүлийн 29.1.4 “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үр өгөөжийг сайжруулах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналт хийх иргэд, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан хөндлөнгийн орон тооны бус ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч Р.Цэдэнбал -Монгол Улсын гавъяат барилгачин
- Гишүүд Р.Сундуйжав- Монгол Улсын гавъяат барилгачин
- Э.Нямдорж -Мэргэшсэн төсөвчин
- А.Энхмөнх -Авто замын инженер
- Н.Амаржаргал -Шугам сүлжээний инженер
- Д.Батсайхан -Барилгын инженер
- Л.Загнаадорж -Барилгын инженер
- Э.Алтан-Од - Архитектор
- Ж. Золбаяр -Цахилгааны инженер
- Б.Загдзүсүм -Сэргээгдэх эрчим хүчний инженер
- Г.Ганзориг - Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
- Д.Эрдэнэбат -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

Нарийн бичгийн
дарга

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалттай барилга байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналт хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламж, төсөл арга хэмжээнд барилгын техникийн хяналтыг үр дүнтэй хийж, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг сар бүр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Р.Цэдэнбал/-д үүрэг болгосугай.

4. Барилгын техникийн хяналт хийхтэй холбогдон гаргах зардлыг Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай барилгын техникийн хяналтын зардлаас ажлын тайлан, гүйцэтгэлийг хянаж олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажлын хэсгийг унаа, шатахуун, урамшуулал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

